

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/248/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/122  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 20,426.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дараах асуудлуудыг хязгаарлалттай дүгнэлтийн үндэс гэж үзлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 16,890.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн
- Цахим төлбөрийн и баримтын бүрдэл хангаагүй 1,989.3 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн,
- ХХОАТ-ыг 1,543.7 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

019020240

## **Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант 89,328.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 31,147.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,159,944.00</b>	<b>39,656,821.88</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>7,159,944.00</b>	<b>39,656,821.88</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>5,298,838.00</b>	<b>26,292,496.88</b>
35110	Тусгай зориулалттай материал	<b>5,294,038.00</b>	<b>7,215,238.00</b>
35130	Эм боох материал	<b>4,800.00</b>	<b>19,077,258.88</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,861,106.00</b>	<b>13,364,325.00</b>
35410	Бичиг хэргийн материал	385,700.00	725,400.00
35420	Аж ахуйн материал	1,420,406.00	2,064,106.00
35440	Түлш шатах тослох материал	55,000.00	137,000.00
35450	Барилга засварын материал		69,300.00
35470	Бусад хангамжийн материал		10,368,519.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>125,749,782.20</b>	<b>196,649,066.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>125,749,782.20</b>	<b>196,649,066.54</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>104,509,782.2</b>	<b>175,409,066.54</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	85,363,236.00	85,363,236.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,092,140.84)	(33,762,545.40)
39203	Авто тээрийн хэрэгсэл	14,800,000.00	14,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,716,666.92)	(14,183,333.64)
39205	Машин тоног төхөөрөмж	48,777,918.00	139,825,714.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,873,874.68)	(26,096,967.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,183,701.00	16,373,373.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,932,390.36)	(6,910,409.50)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,240,000.00</b>	<b>21,240,000.00</b>
39301	Программ хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
39304	Бусад биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>132,909,726.20</b>	<b>236,305,888.42</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>16,890,235.11</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>16,890,235.11</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>16,890,235.11</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	5,945,935.96
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	10,944,299.15
<b>653.31</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>132,909,726.20</b>	<b>219,415,653.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>132,909,726.20</b>	<b>219,415,653.31</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,292,927.00	130,292,927.00
51101	Өмч:-төрийн	130,292,927.00	130,292,927.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(50,156,203.80)</b>	<b>36,349,723.31</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(50,156,203.80)	(50,156,203.80)
51220	Тайлант үеийн үр дүн		86,505,927.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,773,003.00	52,773,003.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>132,909,726.20</b>	<b>236,305,888.42</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>237,532,727.00</b>	<b>665,222,083.51</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>127,014,327.00</b>	<b>224,757,146.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>127,014,327.00</b>	<b>224,757,146.51</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>127,014,327.00</b>	<b>193,610,108.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,755,093.00	104,281,640.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	216,580.00	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	36,042,654.00	89,328,468.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		31,147,038.51
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>110,518,400.00</b>	<b>440,464,937.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>110,518,400.00</b>	<b>440,464,937.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,518,400.00	440,464,937.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>219,222,495.64</b>	<b>578,716,156.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>219,222,495.64</b>	<b>578,716,156.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>211,449,264.67</b>	<b>547,575,834.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>135,722,941.51</b>	<b>322,681,388.75</b>
210101	Үндсэн цалин	104,818,566.00	209,797,917.30
210102	Нэмэгдэл	25,802,087.51	87,506,654.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,658,500.00	17,125,000.00
210104	Урамшуулал	1,443,788.00	8,251,817.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,646,208.98</b>	<b>41,680,606.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,381,906.44	28,534,160.08
210202	Тэтгэмжийн даатгал	1,339,047.78	3,354,728.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,071,238.41	2,617,011.03
210204	Ажилгүйдлийн даатгал	259,455.87	652,246.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,594,560.48	6,522,460.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,038,898.50</b>	<b>71,725,458.74</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,053,963.50	3,523,364.59
210302	Түлш, халаалт	16,073,640.00	67,199,499.15
210303	Цэвэр, бохир ус	911,295.00	1,002,595.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,060,370.00</b>	<b>9,373,998.00</b>
210401	Бичиг хэрэг	1,254,100.00	2,115,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,558,000.00	2,533,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,417,370.00	2,578,138.00
210405	Хог хаягдал устгах цэвэрлэх	240,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	655,900.00	1,816,960.00
210408	Бараа материал акталсны зардал	935,000.00	
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>483,700.00</b>	<b>6,803,170.63</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	483,700.00	6,803,170.63
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,338,595.00</b>	<b>40,322,400.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	535,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	595,200.00	
210604	Урсгал засвар	208,395.00	40,322,400.00

Төв аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт зочны зардал</b>	<b>4,920,000.00</b>	<b>17,482,200.00</b>
<b>210702</b>	Дотоод албан томилолт	4,920,000.00	17,482,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,703,898.00</b>	<b>3,135,448.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	369,900.00	460,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	256,600.00	197,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	253,000.00	465,000.00
210807	Газрын төлбөр	63,720.00	63,720.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	1,703,750.00	1,252,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,534,652.68</b>	<b>34,361,363.66</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,250,500.00	3,023,180.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	50,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,964,152.68	30,338,183.66
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,773,230.97</b>	<b>31,140,322.34</b>
	Бусад урсгал шилжүүлэг		13,091,372.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,561,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		529,672.00
	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт</b>		<b>14,250,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		14,250,000.00
	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт</b>	<b>7,773,230.97</b>	<b>3,798,950.34</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,773,230.97	3,798,950.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>18,310,231.36</b>	<b>86,505,927.11</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>18,310,231.36</b>	<b>86,505,927.11</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>201,273,493.00</b>	<b>544,746,577.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,755,093.00</b>	<b>104,281,640.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>90,755,093.00</b>	<b>104,281,640.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>90,755,093.00</b>	<b>104,281,640.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,755,093.00	104,281,640.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>110,518,400.00</b>	<b>440,464,937.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>110,518,400.00</b>	<b>440,464,937.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,518,400.00	440,464,937.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>201,273,493.00</b>	<b>532,837,577.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>201,273,493.00</b>	<b>532,837,577.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>193,500,262.03</b>	<b>501,561,926.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>135,751,791.55</b>	<b>316,600,124.79</b>
210101	Үндсэн цалин	104,818,566.00	204,321,877.92
210102	Нэмэгдэл	25,830,940.67	86,257,604.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,658,496.88	17,085,998.81
210104	Урамшуулал	1,443,788.00	8,934,643.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,646,208.98</b>	<b>41,680,606.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,381,906.44	28,641,628.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,339,047.78	3,349,965.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,071,238.41	2,606,130.18
210204	Ажилгүйдлийн даатгал	259,455.87	651,294.20
210205	Эрүүл мэндийн даатгал	2,594,560.48	6,431,587.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,428,600.00</b>	<b>68,277,159.59</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,053,963.50	3,523,364.59
210302	Түлш, халаалт	14,834,936.50	63,751,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,539,700.00	1,002,595.00
<b>220103</b>	<b>Хангамж бараа материал</b>	<b>7,463,820.00</b>	<b>8,970,588.00</b>
210401	Бичиг хэрэг	1,276,900.00	2,447,600.00
210402	Тээвэр шатахуун	2,908,000.00	2,615,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,417,370.00	2,578,138.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч устгал ариутгал	240,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	621,550.00	999,850.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>364,000.00</b>	<b>6,413,970.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	364,000.00	6,413,970.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,003,595.00</b>	<b>40,988,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	665,000.00	725,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	595,200.00	
210604	Урсгал засвар	743,395.00	40,263,000.00

Төв аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт зочны зардал</b>	<b>4,920,000.00</b>	<b>9,986,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,920,000.00	9,986,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,391,628.00</b>	<b>2,703,148.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		640,000.00
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	369,900.00	460,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	256,600.00	197,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	63,200.00	63,720.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	1,382,000.00	785,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,530,618.50</b>	<b>5,942,330.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,917,618.50	4,942,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	613,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,773,230.97</b>	<b>31,275,650.34</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>13,226,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,561,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		665,000.00
	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>14,250,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		14,250,000.00
	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,773,230.97</b>	<b>3,798,950.34</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,773,230.97	3,798,950.34
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b>11,909,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>11,909,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>11,909,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>11,909,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		11,909,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(11,909,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>(68,466,435.16)</b>	<b>114,599,494.84</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>(68,466,435.16)</b>	<b>114,599,494.84</b>
<b>Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн дүн</b>				
Тайлант үеийн үр дүн			18,310,231.36	18,310,231.36
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>(50,156,203.80)</b>	<b>132,909,726.20</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>(50,156,203.80)</b>	<b>132,909,726.20</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			86,505,927.11	86,505,927.11
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>36,349,723.31</b>	<b>219,415,653.31</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>617,409,000.00</b>	<b>476,954,140.00</b>	<b>140,454,860.00</b>	<b>77.3%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>617,409,000.00</b>	<b>476,954,140.00</b>	<b>140,454,860.00</b>	<b>77.3%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>603,847,300.00</b>	<b>463,727,440.00</b>	<b>140,119,860.00</b>	<b>76.8%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>443,279,600.00</b>	<b>307,760,707.79</b>	<b>135,518,892.21</b>	<b>62.0%</b>
Үндсэн цалин	329,708,000.00	204,321,877.92	125,386,122.08	60.3%
Нэмэгдэл	79,276,300.00	77,418,187.13	1,858,112.87	97.7%
Унаа хоолны хөнгөлөлт	16,978,500.00	17,85,998.81	(107,498.81)	100.6%
Урамшуулал	17,316,800.00	8,934,643.93	8,382,156.07	51.6%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>42,335,500.00</b>	<b>40,656,036.62</b>	<b>1,679,463.38</b>	<b>96.0%</b>
Тэтгэврийн даатгал	28,788,100.00	27,887,005.10	901,094.90	96.9%
Тэтгэмжийн даатгал	3,386,800.00	3,262,381.98	124,418.02	96.3%
ҮОМШӨ-ний даатгал	2,709,500.00	2,535,106.32	174,393.68	93.6%
Ажилгүйдлийн даатгал	677,400.00	633,776.60	43,623.40	93.6%
Эрүүл мэндийн даатгал	6,773,700.00	6,337,766.62	435,933.38	93.6%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>68,852,900.00</b>	<b>68,277,159.59</b>	<b>575,740.41</b>	<b>99.2%</b>
Гэрэл, цахилгаан	3,562,000.00	3,523,364.59	38,635.41	98.9%
Түлш, халаалт	63,751,200.00	63,751,200.00	0.00	100.0%
Цэвэр, бохир ус	1,539,700.00	1,002,595.00	537,105.00	65.1%
<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>8,145,000.00</b>	<b>7,970,588.00</b>	<b>174,412.00</b>	<b>97.9%</b>
Бичиг хэрэг	2,450,000.00	2,447,600.00	2,400.00	99.9%
Тээвэр шатахуун	1,615,000.00	2,615,000.00	0.00	100.0%
Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,750,000.00	2,518,138.00	171,862.00	93.8%
Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал	330,000.00	330,000.00		100.0%
Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,850.00	150.00	100.0%
<b>Норматив зардал</b>	<b>6,420,000.00</b>	<b>6,413,970.00</b>	<b>6,030.00</b>	<b>99.9%</b>
Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	6,420,000.00	6,413,970.00	6,030.00	99.9%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>14,017,500.00</b>	<b>982,500.00</b>	<b>93.5%</b>
Багаж техник хэрэгсэл	10,000,000.00	8,754,500.00	1,245,500.00	87.5%
Урсгал засвар	5,000,000.00	5,263,000.00	(263,000.00)	105.3%
<b>Томилолт зочны зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>9,986,000.00</b>	<b>14,000.00</b>	<b>99.9%</b>
Дотоод албан томилолт	10,000,000.00	9,986,000.00	14,000.00	99.9%

Төв аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>3,814,300.000</b>	<b>2,703,148.00</b>	<b>1,111,152.00</b>	<b>70.9%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	750,000.00	640,000.00	110,000.00	85.3%
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	460,000.00	460,000.00		100.0%
Даатгалын үйлчилгээ	473,000.00	197,500.00	275,500.00	41.8%
Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	34,928.00	71,572.00	32.8%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,800.00	22,000.00	8,800.00	71.4%
Мэдээллийн технологийн зардал	500,000.00	500,000.00		100.0%
Газрын төлбөр	64,000.00	63,720.00	280.00	99.6%
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00		30,000.00	
Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	1,400,000.00	785,000.00	615,000.00	56.1%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>5,942,330.00</b>	<b>57,670.00</b>	<b>99.0%</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,942,330.00	57,670.00	98.8%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00		100.0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,561,700.00</b>	<b>13,226,700.00</b>	<b>335,000.00</b>	<b>97.5%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,561,700.00</b>	<b>13,226,700.00</b>	<b>335,000.00</b>	<b>97.5%</b>
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,561,700.00	12,561,700.00		100.0%
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	665,000.00	335,000.00	66.5%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>484,652,500.00</b>	<b>480,506,140.00</b>	<b>4,146,360.00</b>	<b>99.1%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>390,474,500.00</b>	<b>390,474,500.00</b>		<b>100.0%</b>
Улсын төсвөөс санхүүжих	390,474,500.00	390,474,500.00		100.0%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>94,178,000.00</b>	<b>90,031,640.00</b>	<b>4,146,360.00</b>	<b>95.6%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,178,000.00	90,031,640.00	4,146,360.00	95.6%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00		100.0%
Удирдах ажилтан	1	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00		100.0%
Үйлчлэх ажилтан	1.00	1.00		100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>49,990,437.00</b>	<b>49,743,486.66</b>	<b>246,950.34</b>	<b>99.5%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>49,990,437.00</b>	<b>49,743,486.66</b>	<b>246,950.34</b>	<b>99.5%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>49,990,437.00</b>	<b>49,743,486.66</b>	<b>246,950.34</b>	<b>99.5%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>8,965,867.34</b>	<b>8,839,417.00</b>	<b>126,450.34</b>	<b>98.6%</b>
Нэмэгдэл	8,965,867.34	8,839,417.00	126,450.34	98.6%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>1,024,569.66</b>	<b>1,024,569.66</b>		<b>100%</b>
Тэтгэврийн даатгал	754,623.00	754,623.00		100%
Тэтгэмжийн даатгал	87,584.00	87,584.00		100%
ҮОМШӨ-ний даатгал	71,023.86	71,023.86		100%
Ажилгүйдлийн даатгал	17,517.60	17,517.60		100%
Эрүүл мэндийн даатгал	93,821.20	93,821.20		100%
<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>		<b>100%</b>
Тээвэр шатахуун	1,000,000.00	1,000,000.00		100%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,000,000.00</b>	<b>38,879,500.00</b>	<b>120,500.00</b>	<b>99.7%</b>
Багаж техник хэрэгсэл	4,000,000.00	3,879,500.00	120,500.00	97.0%
Урсгал засвар	35,000,000.00	35,000,000.00		100.0%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,990,437.00</b>	<b>9,990,437.00</b>		<b>100.0%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>9,990,437.00</b>	<b>9,990,437.00</b>		<b>100.0%</b>
Улсын төсвөөс санхүүжих	9,990,437.00	9,990,437.00		100.0%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>		<b>100.0%</b>
Удирдах ажилтан	1	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00		100.0%
Үйлчлэх ажилтан	1.00	1.00		100.0%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь тус аймгийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг, Стандарт, Хэмжил зүйн газарт санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Монгол улсын Шадар сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээ олгох
- Хэмжих хэрэгсэл, хэмжүүр баталгаажуулалтыг хүндийн хэмжил, цахилгаан соронзонгийн хэмжил, эзлэхүүн багтаамж хийн шингэний зарцуулалтын хэмжээ
- Стандарт мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлж, салбар сан үүсгэн стандартыг цахим хэлбэрээр хадгалах
- Сорьцын хяналт тавих

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 36 арга хэмжээтэй баталснаас нийт 81.4 %-тай дүгнэгдсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Стандартчилал, хэмжил зүйн тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Стандарт, Хэмжил Зүйн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,396.8 мянган төгрөгөөр буюу 77.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	7,159.9	39,656.8	32,496.8
Үндсэн хөрөнгө	125,749.7	196,649.0	70,899.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>132,909.7</b>	<b>236,305.8</b>	<b>103,396.1</b>
Өр төлбөр		16,890.2	(16,890.2)
Засгийн газрын хувь оролцоо	132,909.7	219,415.6	86,505.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>132,909.7</b>	<b>236,305.8</b>	<b>103,396.1</b>

Дээрх хүснэгтээс харахад:

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 25,907.7 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 30,549.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тоног төхөөрөмж 91,047.7 мянган төгрөг, тавилга эд хогшил 10,189.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 10,669.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,239.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 80,378.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8,950.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 16,890.2 мянган төгрөгөөр өссөн нь 5,945.9 мянган төгрөгийн НДШ болон ХХОАТ-ын өглөг, 7,496.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал, 3,448.2 мянган төгрөгийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг тус тус төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 219,415.6 мянган төгрөг болж 86,505.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 388,638.2 мянган төгрөгөөр тооцон үүнээс 298,638.2 мянган төгрөгийг Улсын төсвөөс, 90,000.00 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 85,935.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, улсын төсвөөс 380,395.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 94,178.0 мянган төгрөг, нийт 474,564.2 мянган төгрөгөөр тооцон 2023 оны урсгал зардлын төсвийг баталж ирүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 638,135.8 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 494,756.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 494,756.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулаагүй 14,250.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 526,697.6 мянган төгрөг буюу 82.5 хувьтай байна.

Хүснэгт 2.

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71704 Стандартчилал, хэмжил зүй				
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	624,574.1	513,470.9	111,103.2	82.2%
1.2	80227 Лабораторийн итгэмжлэл	750.0	640.0	110.0	85.3%
1.3	80802 Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	13,561.7	13,226.7	335.0	97.5%
	<b>Дүн</b>	<b>638,135.8</b>	<b>526,697.6</b>	<b>111,438.2</b>	<b>82.5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 40,000.0 мянган төгрөг, орон нутгийн цалин хөлсний нэмэгдэл 9,990.4 мянган төгрөг, нийт 49,990.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын зардалд 9,863.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,000.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 38,879.5 мянган төгрөг зарцуулжээ.

Дээд шатны байгууллагаас 49,990.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулаагүй үлдэгдэл 246.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 334,649.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: 33,250.0 төгрөгийн хангамж бараа материал, хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 17,428.6 төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 103,001.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь бараа материалын үнэ өссөн мөн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотойгоор Мэргэжлийн хяналтын газар эрүүл ахуйн лаборатори Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн бүтцэд шилжсэнтэй холбоотойгоор түлш халаалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээ Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 219,222.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,288.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,466.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, эд хогшил худалдан авах зардал 2,103.0 мянган төгрөг, томилолтын зардал 14.0 мянган төгрөг, хангамж материалын зардал 2,640.6 мянган төгрөг, нийт 4,757.6 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, зарцуулан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 155 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	895.5	2	895.5	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>895.5</b>	<b>2</b>	<b>895.5</b>	<b>100%</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 45,026.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 45,026.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн өр төлбөрийн дүнг 7,496.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн ашиг, алдагдлын дүн 18,310.2 мянган төгрөгийг зөрүүтэй тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал зардлын дүн 18,900.5 мянган төгрөгийн зөрүүтэй Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд 320.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар 20,423.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 18,879.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 1,543.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 5.1 Албан шаардлага

1. Анхан шатны баримтыг бүрдүүлэлт дутуу, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийсэн 1,989.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг,” гэж заасантай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;” гэж заасныг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд түлш халаалтын тооцоо 3,448.3 мянган төгрөг, дотоод албан томилолтын тооцоо 7,496.0 мянган төгрөг, ХХОАТ-т 2,949.7 мянган төгрөг, НДШ-д 2,996.3 мянган төгрөг нийт 16,890.3 төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.18-д “ заавал биелүүлэх үүрэг нь хуулиар хүлээсэн үүрэг эсвэл хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг байж болно. Заавал биелүүлэх үүрэг нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээний аль алинаас үүсэж болно. Өр төлбөр үүсэхэд хүргэхийн тулд гадна талын өмнө үүрэг хүлээсэн байх ёстой. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"

Шийдвэрлэсэн: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;” гэж заасныг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ,

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ”; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн

албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Цалин хөлсний тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин хөлсний тооцооны хүснэгтээрх цалингийн зардлыг ХХОАТ-ын тайлангийн дүнтэй тулгахад 1,543.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх” зарчмыг хэрэгжүүлэн ажиллах”

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсний тооцооллыг үндэслэн холбогдох татварын тайланг бэлтгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн өр төлбөрийн дүнг	1	7,496.0	1	7,496.0			1	7,496.0				
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн ашиг, алдагдлын дүн зөрүүтэй	1	18,310.2			1	18,310.2	1	18,310.2				
Төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал зардлын дүн	1	18,900.5			1	18,900.5	1	18,900.5				
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд	1	320.0	1	320.0			1	320.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>45,026.7</b>	<b>2</b>	<b>7,816.0</b>	<b>2</b>	<b>37,210.7</b>	<b>4</b>	<b>45,026.7</b>				

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтыг бүрдүүлэлт дутуу	1	1,989.3			1	1,989.3						
Албан томилолт, түлш шатахууны өр төлбөртэй	1	16,890.3			1	16,890.3						
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүй	1	-							1	-		
ХХОАТ-ын тайланг зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	1,543.7					1	1,543.7				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>20,423.3</b>			<b>2</b>	<b>18,879.6</b>	<b>1</b>	<b>1,543.7</b>	<b>1</b>	<b>-</b>		



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 87-17225502-ТӨА-2024/248/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд түлш халаалтын тооцоо 3,448,299.15 төгрөг, дотоод албан томилолтын тооцоо 7,496,000.00 төгрөг, ХХОАТ-ын өглөг 2,949,726.02 төгрөг, НДШ-ийн өглөг 2,996,209.94 төгрөг нийт 16,890,235.00 төгрөгийн өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр, төлбөрийг барагдуулан ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Зуунмод сумын Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Батсайхан, нягтлан бодогч Ц.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 88-17225502-ТӨА-2024/248/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,989,300.00 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалт хийсэн цаг тухайд нь НӨАТ-ын баримтад бүртгүүлж сар бүрийн 10-ны дотор бэлтгэн нийлүүлэгчтэй НӨАТ-ын тулгалт хийх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040033

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Зуунмод сумын Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Батсайхан, нягтлан бодогч Ц.Цэнд-Аюуш нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар \_\_\_\_\_

97-17225502-ТӨА-2024/248/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Ц.Цэнд-Аюушид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Батсайхан, нягтлан бодогч Ц.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ